

**“ЖИДАКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хурал 2022 оны 4-р сарын 23 –ний өдрийн 13:00 цагт Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, орхон-1, Шинэ монгол хаад групп ХХК-ийн байр, 2 давхарын хурлын танхимд хуралдав.

Хуралд оролцсон:

1. Т.Төгс-Од /Хурлын дарга/
2. Lee Jeoung Ho /“Эм Ди Кэй Ай” ХХК-г/ төлөөлж /Хувьцаа эзэмшигч/
3. А.Хос-Эрдэнэ /Тооллогын комиссын дарга/

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга А.Хос-Эрдэнэнийн танилцуулснаар:

“Жидакс” ХК-ийн нийт гаргасан 13,735,752 ширхэг хувьцаа байгаагаас 13,735,752 ширхэг саналын эрхтэй хувьцаатай бөгөөд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2022 оны 4-р сарын 2-ны өдрийн байдлаар нийт 166 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 13,607,865 ширхэг хувьцаатай “Эм Ди Кэй Ай” ХХК буюу 99.07 хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсон Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэхь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дүгээр заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов. Оролцсон хувьцаа эзэмшигч:

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшил хувь
1	“Эм Ди Кэй Ай” ХХК-г төлөөлж Lee Jeoung Ho	13,607,865	99.07%
Нийт		13,607,865	99.07%

Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 03-р сарын 12-ний өдрийн нэгдүгээр тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг хэлэлцэх тухай.

Т.Төгс-Од: Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан болон санхүү байдлын тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах,

Lee Jeoung Ho: Цаашид компанийн үйл ажиллагаа илүү тогтворжиж компанийн ашиг өснө гэдэгт найдаж байна. Иймээс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг батлах саналтай байна.

Шийдвэр 1:

Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан болон санхүү байдлын тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 2: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.

Т.Төгс-Од: 2021 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай холбогдуулан ТУЗ-н гишүүдэд цалин урамшуулал олгох боломжгүй байна.

Lee Jeoung Ho: Компанийн үйл ажиллагаа тогтвортой хэвийн явагдаж эхлэхээр цалин урамшуулал олгоно гэдэгт итгэж байна. Иймд энэхүү саналыг дэмжиж байна.

Шийдвэр 2:

Компани 2021 онд ТУЗ-ийн цалин, урамшуулал олгохгүй байхаар БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 3: ТУЗ-ийн гишүүдийг танилцуулах тухай.

Т.Төгс-Од: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дараах нэр бүхий гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан сонгох,

Хараат бус гишүүд:

- Жаргалсайхан овогтой Билэгдэмбэрэл
- Бямбаа овогтой Ариунболд
- Лхагвасүрэн овогтой Ганчимэг

Ердийн гишүүд:

- Lee овогтой Jeoung Ho
- Доржготов овогтой Пүрэвдорж
- Бямбаа овогтой Нарантуяа
- Дашням овогтой Гантуул
- Төмөрбаатар овогтой Төгс-Од

Т.Төгс-Од: Нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлсэн ТУЗ-ын ердийн гишүүнд Дорлигжав овогтой Болормааг нэг жилийн хугацаатайгаар томилох,

Lee Jeoung Ho: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан сонгох, ТУЗ-ын ердийн гишүүнд Д.Болормааг томилохыг зөвшөөрч байна.

Шийдвэр 3:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр дараах гишүүдийг улируулан сонгосугай.

Хараат бус гишүүд:

- Жаргалсайхан овогтой Билэгдэмбэрэл
- Бямбаа овогтой Ариунболд
- Лхагвасүрэн овогтой Ганчимэг

Ердийн гишүүд:

- Lee овогтой Jeoung Ho
- Доржготов овогтой Пүрэвдорж
- Бямбаа овогтой Нарантуяа
- Дашням овогтой Гантуул
- Төмөрбаатар овогтой Төгс-Од
- Дорлигжав овогтой Болормаа нарыг сонгосугай.

Хурлын дарга Т.Төгс-Од хуралд оролцогсдод талархал илэрхийлж 14:00 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

Танилцсан Хурлын дарга:

